

Монгол Улсын Хэвлэл Мэдээллийн Эрх Чөлөөний Тухай Хуулийн Төсөлд Өгөх Санал

Нээлттэй Нийгэм Форумын “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд өгөх саналыг толилуулж байна. Энэхүү саналыг “Хууль ба Ардчиллын Төв” Олон улсын хүний эрхийн ТББ-ын гүйцэтгэх захирал Тоби Мендел боловсруулсан агаад тэрбээр 2002 оноос эхлэн Монгол дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудалд анхаарлаа хандуулан ННФ-тай хамтран ажиллаж буй юм.

ОРШИЛ

Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг (төсөл) Ерөнхийлөгчийн зөвлөх иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийнхэнтэй удаа дараа зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулжээ. Одоогийн эрх зүйн орчин нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бүрэн хамгаалж чадахгүй байна гэсэн үзэл бодол гол сонирхогч талуудын дунд бий болсон нь төслийг боловсруулах сэдлийг төрүүлсэн болов уу гэсэн сэтгэгдэл төрж байна. Үүний нэг шалтгаан бол Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай 1997 оны хуульд бодитой хэрэгжиж, үр дүн бий болгох дөрөвхөн заалт байгаатай холбоотой байж болох юм (Тухайлбал: хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан хууль гаргахыг хориглох, хэвлэл мэдээллийн байгууллага нийтлэл, нэвтрүүлгийнхээ агуулгыг өөрсдөө хариуцах, нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад хяналт (цензур) тавихыг хориглох, радио, телевизийн үйл ажиллагааг төрөөс хянахыг хориглох, төрөөс өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулахыг хориглох).

Хуулийн төслийг боловсруулсан санаа зорилго нь зөв зүйтэй гэдэгт эргэлзэх зүйл алга. Гэвч төслийн олон заалт хуулийн техникийн болон олон улсын эрх зүйн талаас асуудалтай тулгарч байна. Мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулан хэрэгжүүлэх чиглэлд үр нөлөө багатай болжээ. Харин мэдээллийн эх сурвалжийг нууцлах хамгаалалтыг бий болгосон нь Монгол дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний

хамгаалалтыг өргөжүүлэхэд чухал алхам болсон байна. Гэвч өөрийн зохицуулалтын тогтолцоонд холбогдох заалтууд нь шулуухан хэлэхэд хэрэгжихээргүй буюу уг зорилгыг хангах хэмжээнд нарийвчилсан зохицуулалт болоогүй байна. Бусад асуудлын хувьд (хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө, мэдээлэл олж авах, бусдыг гутаан доромжлох) мөн адил зохицуулалт нь хэрэгтэй үр дүн авчирна гэхэд хэтэрхий ерөнхий, дэндүү хангалтгүй боловсруулсан байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хамгаалах зорилготой хуульд агуулагдаж байвал тустай хэд хэдэн элемент байдаг боловч дээрх хуулийн төсөлд эдгээр нь бүгд буюу олонх нь тусгалаа олж чадаагүй болохыг дурдах нь зүйтэй болов уу. Ийм төрлийн хуульд дараах зүйлийг тусгасан байдаг. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг олон улсын стандартын дагуу хүндэтгэх тухай заах.
- Редакцийн хараат бус байдлыг хүндэтгэх, хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах эрх, удирдагч нараа шүүмжлэх эрх гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөний хэд хэдэн онцлогийг зааж өгөх.
- Хуулиар урьдаас ойлгомжтой тогтоосноос бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагад татан, ял тулгахаас хамгаалагдах тухай заах.



Тоби Мендел

Тоби Мендел нь “Хууль ба Ардчиллын Төв” Олон улсын хүний эрхийн ТББ-ын гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тус байгууллага нь ардчиллын үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх, эвлэлдэн нэгдэх эрхтэй холбоотой хуульзүйн болон бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг. Тэрбээр өмнө нь хэвлэлийн эрх чөлөө ба мэдээлэл авах эрхийн талаар үйл ажиллагаа явуулдаг “19-р Артикл” хүний эрхийн төрийн бус байгууллагын хуулийн салбарын дэд захирлаар 12 жил ажиллаж байсан агаад энэ чиглэлээр Дэлхийн Банк, НҮБ, засгийн газрууд болон дэлхийн олон орны төрийн бус байгууллагуудад зөвлөлгөө өгдөг болно.

Түүнчлэн Тоби Мендел “Глоб Интернэйшнл” ТББ-тай хамтран хэвлэл мэдээллийн дотоод орчны талаар тайлан гаргаж, Дэлхийн Банкны мэдээллийн орчныг бий болгох үнэлгээнд экспертээр ажиллажээ. Мөн Ази Номхон Далайн Өргөн Нэвтрүүлгийн Хөгжлийн Институттай хамтран Монголын өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг боловсруулсан байна.

- Сонин, хэвлэлийг бүртгүүлэх шаардлагыг цуцлах эсвэл одоо байгаа тогтолцоонд томоохон өөрчлөлт хийх.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд зохицуулалт нь ойлгомжтой байх.

Энэхүү саналын зорилго нь хуулийн төсөлд олон улсын стандарт болон бусад улс орон дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохицуулж байгаа илүү сайн туршлагыг аль болох бүрэн гүйцэд тусгаж оруулахад туслахад оршино. Саналыг Нээлттэй Нийгэм Форумас Эрх зүй, ардчиллын төвд ирүүлсэн хуулийн төслийн албан бус орчуулгыг үндэслэж боловсруулав.

САНАЛ

1. Нэр томъёо

Хуулийн төслийн 3-р зүйлд нэр томъёог заажээ. “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэж бүх төрлийн радио, телевиз, сонин, сэтгүүл, хэвлэл мэдээллийн байгууллагын эрхлэн гаргадаг цахим мэдээллийг хэлнэ гэсэн нь зарим талаар уг ойлголтыг өөрийг нь өөрөөр нь тодорхойлсон байдалтай болжээ. Харин хэвлэл мэдээллийн байгууллагыг “нийтлэлийн бодлогыг тодорхойлох, нийтлэлийн агуулгыг бэлтгэх болон хэвлэн нийтлэх үйл ажиллагааг эрхэлж буй этгээдийг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Энэ тодорхойлолтыг өнгөн талаас нь дүгнэж хэлэхэд туйлын өргөн агуулгатай болжээ. “Бодлого тодорхойлох” гэдгийг хэрхэн ойлгохоос хамаараад радио, телевиз, сонин, хэвлэл, тэр ч байтугай интернэтээр мэдээлэл түгээж байгаа ямар ч этгээдийг хэвлэл мэдээллийн байгууллагад хамааруулж үзэж болох талтай байна. Цахим мэдээлэл гэдэгт төрийн бус байгууллага эсвэл шашны байгууллага, их дээд сургууль зэрэг бусад иргэний нийгмийн байгууллагаас гаргаж байгаа “сэтгүүл” гэж үзэж болох бүх материал багтаж мэдэхээр харагдаж байна. Мөн олон төрлийн цахим мэдээлэл тухайлбал, хувийн веб сайтууд, хувь хүний болон нийтийн блогууд үүнд хамаарахаар байгаа нь бүр ч асуудал үүсгэж байна.

Гэтэл нөгөө талаас хуулийн төслийн мөн чанар хийгээд уг төсөл нь өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болгож, мэдээллийн эх сурвалжийг хамгаалах гэсэн оролдлого хийж байгаагаас үзэхэд уг хууль ийм олон төрлийн мэдээллийг хамарч үйлчлэх зорилгогүй болох нь тодорхой мэт. Цаашилбал, хуулийн төслийн зарим заалт тухайлбал зар сурталчилгааны болон өмчлөлийг ил тод болгоход чиглэсэн заалтууд дээрх олон төрлийн байгууллагад хамаарч үйлчилнэ гэвэл асуудалтай болж ирэхээр байна.

Хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг тогтмол гардаг (жишээ нь, сард дор хаяж нэг удаа), тогтсон нэртэй, редакц хийсэн агуулга бүхий, нийтэд тараадаг, олон нийтэд эсвэл тодорхой бүлэгт зориулсан гэх зэрэг хэд хэдэн ойлгомжтой, онцлог шинжээр нь тодорхойлж өгвөл илүү оновчтой байж болох юм. Тодорхойлолт нь сонин, сэтгүүлийг мөн жишээ болгон дурдаж болох юм.

Радио, телевизийг мөн л ерөнхий шинжээр нь дээрхийн адил тодорхойлох нь зүйтэй. Эдгээр шинж нь газар дээрх долгион цацруулагч, кабель, хиймэл дагуулаар дамжуулан нийтийн хэрэгцээнд зориулан захиалгаар эсвэл захиалга авахгүйгээр хэрэглэгч радио, телевиз, бусад цахим төхөөрөмжөөр нэгэн зэрэг хүлээн авах зориулалтаар нэвтрүүлэг цацах гэсэн агуулгыг илэрхийлнэ. Дээрх тодорхойлолтод үл багтах тохиолдлыг ч тухайлбал байгууллагын доторх харилцаа холбоог мөн зааж өгч болох юм.

Интернэтээр түгээх мэдээллийг багтаан авч үзэх тухай асуудлыг тусгайлан анхаарах шаардлагатай. Нэг талаас, тухайн нэг сонин хэвлэмэл хувилбарыг зохицуулсан хэм хэмжээ уг сонин интернэтэд тавигдсан хувилбарт хамаарахгүй байвал этгээд зохицуулалт бий болно. Радио, телевизийн хувьд ч мөн адил. Нөгөө талаас, дээр дурдсанчлан, хуулийн төслийн үйлчлэлийг интернэт дэх олон төрлийн мэдээлэлд хамааруулж үзэх нь учир дутагдалтай юм. Цаашилбал, уламжлалт мэдээллийн хэрэгслүүд онлайн хувилбар гаргах үед агуулга нь нэлээд өөрчлөгдөж редакцийн хяналт нь суларч ирдэг.¹

Европын зөвлөл “редакц хийсэн” онлайн материал хэмээх ойлголтыг нэвтрүүлсэн байна. Хэвлэл мэдээллийн шинэ орчин дахь хариу өгөх эрхийн талаарх² 2004 оны 16 тоот зөвлөмжид дараах тодорхойлолтыг өгсөн байна:

“Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдэг нь олон нийтэд редакц хийсэн мэдээлэл тогтмол түгээх харилцаа холбооны аливаа хэрэгслийг хэлэх бөгөөд энэ нь онлайн эсвэл офлайн байх эсэх нь ач холбогдолгүй тул сонин, сэтгүүл, радио, телевиз, вебэд суурилсан мэдээний үйлчилгээ зэргийг хамааруулж үзнэ.

Энэхүү тодорхойлолт нь эрх зүйн зохицуулалт онлайн материалд хамаарч үйлчлэх хүрээг хязгаарлах давуу талтай байна. Монголд анхаарч үзүүштэй бас нэг арга бол хуулийн төслийг хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл болон радио, телевиз, тэдгээрийн онлайн хувилбарт хамаарч үйлчлэхээр зохицуулж болох юм. Ингэснээр

¹ Жишээ нь Guardian сонин онлайн хувилбар нь зарим тодорхой стандартыг дагах ёстой байдаг боловч хэвлэмэл хувилбараасаа сул байдаг.
² 2004 оны 12 сарын 15 нд Сайд нарын зөвлөлөөр батлагдсан.

хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн хэвлэл мэдээлийн хэрэгсэл гэх ойлголтоор хязгаарлаж, ойлгомжтой болгох давуу талтай юм. Нөгөө талаас зөвхөн онлайн хэлбэртэй оршдог хэвлэл мэдээлийн хэрэгслийг хуулийн гадна үлдээх ялимгүй сул тал байгаа боловч одоогийн байдлаар энэ салбар Монголд хүчтэй хөгжөөгүй байгаа учир тийм ч ноцтой асуудал биш юм.

“Хэвлэл мэдээлийн хэрэгсэл” болон “хэвлэл мэдээлийн байгууллага” гэсэн тодорхойлолтын хувьд бас нэг анхаарал татаж байгаа зүйл бол эдгээрийг зааглаж тус тусад нь тодорхойлолт өгсний учрыг ойлгоход түвэгтэй байна. Хуулийн төсөлд хэвлэл мэдээлийн байгууллагад янз бүрийн нэр томъёо хэрэглэсэн байгааг тэмдэглэх нь зүйтэй. Хэвлэн нийтлэх эрх чөлөөний тухай 4-р зүйлийн 1, нийтлэлийн агуулгыг хариуцах тухай 7-р зүйл, өмчлөл ил тод байх тухай 8-р зүйлд хэвлэл мэдээлийн байгууллага гэж, хэвлэл мэдээлийн эрх чөлөөг хягаарласан хуулийн тухай 4-р зүйлийн 3, өөрийн зохицуулалтын тухай 9-р зүйл, гүтгэх тухай 10-р зүйлд хэвлэл мэдээлэл гэж, төрийн мэдлийн хэвлэл мэдээлийн хэрэгслийн тухай 5-р зүйлийн 1-д хэвлэл мэдээлийн байгууллага гэж, эх сурвалжаа нууцлах тухай 6-р зүйлд нийтлэлийн үйл ажиллагаа гэж тус тус заасан байна.

Зарим заалт (хэвлэн нийтлэх эрхийг хамгаалах, төрийн мэдлийн хэвлэл мэдээлэл, эх сурвалж нууцлах, өмчлөлийн ил тод байдал) нь бүх төрлийн хэвлэл мэдээлийн хэрэгсэлд хамаарч байхад нөгөө хэсэг нь зөвхөн хэвлэмэл мэдээлийн хэрэгсэлд (өөрийн зохицуулалт) хамаатай болох нь илэрхий байна.

3-р зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “хэвлэн нийтлэх үйл ажиллагаа”-г, 3-р зүйлийн 1 дэх хэсгийн 9-т “нийтлэгдээгүй мэдээлэл” гэдгийг тодорхойлжээ. Хуулийн төсөлд эдгээр ойлголтыг хэрэглэх нь хэрэглэжээ. Тухайлбал, 4.1-д мэдээлэл нийтлэх эрх, 6.2-т нийтлэгдсэн болон нийтлэгдээгүй мэдээлийн эх сурвалжийг хамгаалах, 7.4-т нийтлээгүй, нэвтрүүлээгүй мэдээлийн төлөө төлбөр авахгүй байх тухай тус тус заажээ. Эдгээр зохицуулалтыг бий болгоход дээрх ойлголтууд зайлшгүй шаардагдаж байгаа эсэх нь ойлгомжгүй байна. Нэгд, цаад тулгуур ойлголт нь өөрөө ойлгомжтой зүйлүүд (өөрөөр хэлбэл, тухайн материал нийтлэгдсэн, нийтлэгдээгүй байх эсэх нь мэдээжийн зүйл байдаг). Хоёрт, эх сурвалжийн тухайд асуудлын гол нь тухайн материал хэвлэгдсэн, хэвлэгдээгүйд бус эх сурвалжаа заасан байна уу үгүй юу гэдэгт байдаг.

Цаашилбал, “хэвлэн нийтлэх үйл ажиллагаа” нь нийтэд түгээх зорилгоор баримт мэдээлэл олж авахын зэрэгцээ мэдээлийн эх сурвалжаа хамгаалах үйл ажиллагааг хэлж байна. Үүнтэй төстэйгээр “нийтлэгдээгүй мэдээлэл” гэх ойлголтыг тодорхойлохдоо эх сурвалжаа нуух асуудлыг бас хөндсөн байна. Ер нь эх сурвалжаа нуух шаардлага гарахгүй байх тохиолдол олон. Мэргэжлийн сэтгүүлчид

харин ч нууцлал хадгалах үүрэг хүлээгээгүй бол эх сурвалжаа заах ёстой. Ямартай ч эх сурвалж нууцлах гэсэн санаа нь мэдээллийг нийтлэх, нийтлэхгүй байх тухай санаатай логикийн хувьд холбоогүй байна.

Хэвлэн нийтлэх гэдэг бол олон нийтэд мэдээлэл түгээх тухай ойлголт. Эх сурвалжийн тухай асуудал бол хэдийгээр нийтлэх гэж байгаа мэдээлийн эх сурвалжийг хамгаалах шаардлага үүсч болох боловч хэвлэн нийтлэх тухай ойлголтод хамааралгүй юм. Өөрөөр хэлбэл, эх сурвалж хамгаалах тухай ойлголтыг өөрийг нь өөрөөр нь тодорхойлоход хүрч байна гэсэн үг. Харин нийтлэгдээгүй мэдээлийн тухайд логикгүй байдал харагдаж байна. Эх сурвалжаа нууж байгаа нөхцөлд нийтлэгдээгүй мэдээлийн төлөө төлбөр авахгүй харин эх сурвалж нь нууц биш бол төлбөр авч болох юм.

3-р зүйлийн 1 дэх хэсгийн 3-т “хэвлэл мэдээлийн ёс зүйн өөрийн зохицуулалтын тогтолцоо” гэж хэвлэл мэдээлийн хэрэгслийн үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ тогтоох, хэвлэл мэдээлийн агуулгад олон нийт хяналт тавих эрхээ эдлэх хэрэгслийг хангаж буй төрийн бус, олон нийтийн байгууллагуудыг хэлнэ гэжээ. Энэ нь 9-р зүйлд өөрийн зохицуулалтын тухай заасан зүйл дээр юу нэмсэн нь ойлгомжгүй байна (эдгээр саналын талаар дор хийсэн дүн шинжилгээг үзнэ үү). Уг тодорхойлолт нь хэтэрхий ерөнхий томъёологдсон учраас ойлгомжтой байх үндэсгүй юм. Тэгсэн атлаа бас хязгаарлалт үүсгэх магадлалтай гэсэн шүүмжлэлд өртөхөд бэлэн байна. (Жишээ нь, хэвлэл мэдээлийн агуулгад олон нийт мониторинг хийж хяналт тавих ёстой болж байна).

3-р зүйлийн 1 дэх хэсгийн 6-д “зар болон сурталчилгааны чанартай мэдээлэл” гэж зар сурталчилгаанд тавих ерөнхий шаардлагыг хангасан боловч агуулгыг нь хэвлэл мэдээлийн байгууллагаас бэлтгээгүй түгээсэн мэдээллийг ойлгоно гэжээ. Энэ тодорхойлолт зар сурталчилгааг өөрийг нь өөрөөр нь тодорхойлсон утгатай болжээ. Үүнийг дараах байдлаар сайжруулж болох юм.

Ямар нэг бараа, үйлчилгээг худалдах, худалдан авах, хөлслөх, ямар нэг үйл хэрэг, санаа бодлыг дэмжүүлэх, зар сурталчилгаа явуулагчийн хүссэн өөр ямар нэг үр дүнг бий болгох зорилготой бөгөөд хариу төлбөртэйгээр зар сурталчилгаа явуулагчид нэвтрүүлгийн цаг, сонин сэтгүүлийн талбай гаргаж өгснөөр нийтэд хүргэж байгаа аливаа мэдээллийг зар сурталчилгаа гэнэ.

3-р зүйлийн 1 дэх хэсгийн 8-д “мэдээлийн эх сурвалж” гэж мэдээлэл өгөгч, түүний нэр, хаяг, болон бусад мэдээлэл өгөгчийн хэн болохыг нь тогтооход шууд бусаар ашиглагдах мэдээллийг хэлнэ гэж тодорхойлсон нь хоёр өөр зүйлийг хооронд нь хольж байна. Мэдээлийн эх сурвалж болон уг эх сурвалж хэн болохыг танигдуулах мэдээлэл гэсэн хоёр зүйл байгааг зааглан авч үзэх нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ:

- “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” болон “хэвлэл мэдээллийн байгууллага” гэсэн ойлголтыг зохих хэмжээнд нарийвчилж хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл болон радио, телевиз гэсэн ойлголтуудаар сольж, эдгээрийг хамтад нь хэвлэл мэдээллийн байгууллага гэдэг ойлголтоор авч үзэх.
- Хуулийн үйлчлэх хүрээг хэвлэл мэдээллийн байгууллагын онлайн хувилбар (эсвэл олон нийтийн хэрэгцээнд зориулан тогтмол гаргадаг, хянан тохиолдуулсан онлайн материал)-аар хязгаарлах.
- “Хэвлэн нийтлэх” болон “нийтлэгдээгүй мэдээлэл” гэх ойлголтуудыг хуулиас хасах асуудлыг авч үзэх. Хэрэв тэдгээрийг хэвээр үлдээвэл нууц эх сурвалжийн тухай ойлголтыг хасах нь зүйтэй.
- 3-р зүйлийн 1 дэх хэсгийн 3-т байгаа өөрийн зохицуулалтын тогтолцооны талаарх заалтыг хасах асуудлыг авч үзэх эсвэл уг заалтыг бүр их ойлгомжтой, яв цав болгох.
- Зар сурталчилгааны тухай ойлголтын тодорхойлолтыг өөрчлөн сайжруулж, дээр санал болгосон байдлаар тухайн ойлголтыг өөрийг нь өөрөөр нь тодорхойлсон алдааг залруулах.
- Мэдээллийн эх сурвалжийн тухай ойлголтыг уг эх сурвалжийг танигдуулах мэдээллийн тухай ойлголтоос зааглаж өгөх.

2. Ерөнхий хамгаалалтууд

Хуулийн төсөлд хэд хэдэн ерөнхий хамгаалалт оруулжээ. 4-р зүйлд ийм гурван хамгаалалтыг заасан байна. Үүнд: 1. Хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл авах, хайх, түгээх, баримтыг шалгах, эрэн сурвалжлах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг чөлөөтэй, хараат бусаар явуулах эрхтэй. 2. Төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн агуулгад хяналт (цензур) тавих, шалгалт зохион байгуулахыг хориглоно. 3. Улсын Их Хурал хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.

Эдгээр заалтын санаа зорилго нь сайшаалтай байна. Гэвч түүний зэрэгцээ сайжруулах зүйл бас байна. 4.1-д “1. Хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл авах, хайх, түгээх, баримтыг шалгах, эрэн сурвалжлах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг чөлөөтэй, хараат бусаар явуулах эрхтэй.” Энэ заалт сайшаалтай байгаа боловч бас л маш ерөнхий болжээ. Цаашилбал, энэ заалт яг асуудлынхаа мөн чанарыг олж зохицуулж чадаагүй байна. Тодруулбал, эдгээр эрх нь туйлын эрх биш учраас чухам ямар нөхцөлд хязгаарлалт тавьж болох вэ гэдэг асуудал тулгарч байна. Жишээ нь, хуульд эдгээр эрхэд тавих хязгаарлалт нь өөрөө ямар хязгаарт байх вэ гэдгийг зааж өгсөн бол зүгээр байжээ. Үүнээс үзэхэд хуульд аливаа хязгаарлалт нь ойлгомжтой, нийтэд ил тодорхой хэлбэрээр гарсан байх бөгөөд хуульд заасан бусад илүү чухал ашиг сонирхол (үндэсний аюулгүй байдал, бусдын эрх)-д үйлчлэх зорилгоор хязгаарлалт тавьж болно гэж томъёолж болох юм.

4.2.-т төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн агуулгад хяналт (цензур) тавих, шалгалт зохион байгуулахыг хориглоно гэжээ. Энэ заалтыг шууд утгаар нь ойлговол цагдаагийн байгууллага

бусдыг үзэн ядсан, гэмт хэрэгт уриалан дуудсан, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулсан материал тараасан мэдээлэл авсан тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулж болохгүй болж байна. Мэдээж ийм зохицуулалт хэмээс хэтэрнэ. Цаашилбал, ийм заалт дан ганц хэвлэл мэдээллээр ч хязгаарлахгүй үйлчилнэ. Энэ заалтыг зүгээр л хэвлэл мэдээлэлд цензур тавьж болохгүй гэсэн агуулгаар ойлгомжтой томъёолох нь зүйтэй.

4.3 нь Улсын Их Хурал хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно гэжээ. Хэдийгээр энэ заалтаар нэг чухал болгоомжлолыг илэрхийлж байгаа нь бахархуштай байгаа боловч хууль зүйн талаасаа энэ нь ач холбогдолгүй зүйл юм. Нэгд, Үндсэн хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг нэгэнт баталгаажуулсан ба бусад хуульд үүнийг наанадаж зарчмын хувьд хүндэтгэж дагах ёстой. Хоёрт, энэ хууль бол Улсын Их Хурлаас баталсан ердөө л парламентын эрх хэмжээний хууль. Тиймээс Улсын Их Хурал дахиад нэг хууль гаргаад л энэ заалтыг хүчингүй болгочихно. Тэгэхээр 4.1-тэй нэгэн адил хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах нөхцлийг тодорхой ойлгомжтой зааж өгвөл илүү үр дүнтэй болно. Ингэсэн тохиолдолд уг заалтыг Үндсэн хуульд илэрхийлэгдсэн зарчмын албан ёсны тайлбар гэж үзэж болох бөгөөд энэ чанараараа бусад хууль тогтоомжид хүндэтгэвэл зохих заалт болох юм. Мэдээж хэрэг Улсын Их Хурал мөн л уг заалтыг өөрчлөх юмуу хүчингүй болгох боломжтой. Гэхдээ тэр цагийг хүртэл шүүх, цагдаа болон бусад этгээд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хүрээ хязгаарыг тогтооход тустай заалт байх болно.

5-р зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно. Зөвхөн хууль, дүрэм журам, түүний төсөл, лавлагаа мэдээлэл

хэвлэн нийтлэх зорилгоор тогтмол хэвлэгддэг эмхтгэл, цахим хаягтай байж болно”.

5.2.-т “Төрийн байгууллага, албан тушаалтан иргэн, байгууллагаас тухайн байгуулагад ирүүлсэн захидал, өргөдөл, гомдол, төрийн, хувь хүний, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нууцтай холбоотойгоос бусад өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг ил тод байлгана” гэж заасан нь тустай боловч энэ заалт нь мэдээлэл авах эрхийг бүрэн дүүрэн зохицуулсан тусгай хуулийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй. Тусгай хуулиар уг эрхийн хамрах хүрээ, хүсэлт гаргах журам, эрхэд үл хамаарах тохиолдол, мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд хаана, хэнд гомдол гаргах зэрэг асуудлыг ойлгомжтой зааж өгөх боломжтой.

7-р зүйлд зааснаар “Хэвлэл мэдээллийн байгууллага эрхлэн гаргасан нийтлэл, нэвтрүүлгийнхээ хариуцлагыг өөрөө хүлээнэ. Зар болон сурталчилгааны чанартай мэдээллийн хариуцлагыг захиалагч хүлээнэ. Хэвлэл мэдээллийн байгууллага түгээж буй мэдээлэл зар болон сурталчилгааны чанартай болохыг илэрхийлсэн ялгах тэмдэглэгээтэй түгээнэ. Хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийг нийтлээгүй, нэвтрүүлээгүйн төлөө бусдаас төлбөр авахыг хориглоно”.

Энэ сүүлчийн заалт чухам ямар асуудлыг хөндөх зорилготой нь ойлгомжгүй байна. Ер нь энд заасан асуудал бол хэвлэл мэдээллийн байгууллага болон

зар сурталчилгаа хийж байгаа этгээд хоорондоо зах зээлийн зарчмаар тохиролцож шийдвэрлэх асуудал юм. Жишээ нь: зар сурталчилгаа захиалсан этгээд нийтлэгдэхээс өмнө зараа буцаагаад авчихаж болно. Тэр тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллага хоосон зайг бөглөх өөр материал байхгүй бол хохирч болно. Иймд хэвлэл мэдээллийн байгууллага төлбөр авдаг байхад болно.

8- р зүйлд “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн хувь эзэмшигчийн талаарх мэдээллийг жил бүр олон нийтэд мэдээлнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хувь эзэмшдэг дараах этгээдийн өмчлөлийн хувь хэмжээг олон нийтэд ил тод мэдээлнэ: төрийн албан хаагч, улс төрийн нам, гадаадын иргэн, хуулийн этгээд” гэжээ.

Ингэж хувь эзэмшигчдийг төрлөөр нь заан нэрлэхийн оронд тодорхой хувь хэмжээ, жишээ нь 2 хувь гэж заагаад түүнээс дээш хувь эзэмшдэг этгээдийг нийтэд мэдээлнэ гээд заахад болох юм. Нэгд, энэ салбар дахь ил тод байдлын асуудлыг зөвхөн тодорхой төрлийн хувь эзэмшигчдийн хувьд авч үзэх нь зохисгүй. Хоёрт, энэ нь ил тод байх үндсэн зарчмаа үгүй хийж байгаа бөгөөд амьдрал дээр асуудал үүсгэж болзошгүй байна. Тухайлбал, хэвлэл мэдээллийн байгууллага хуульд заасан төрөлд хамаарах хувь эзэмшигчийг нуун дарагдуулах гэсэн сонирхолд хөтлөгдөж болох юм.

ЗӨВЛӨМЖ:

- Хуулийн 4.1 болон 4.3 зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж болох нөхцлийг нарийвчлан зааж шүүгч, цагдаагийн ажилтан, бусад албан тушаалтан, хэвлэл мэдээллийнхэнд чиглэл болгох асуудлыг авч үзэх.
- Хуулийн 4.2-т хэвлэл нийтлэлд зөвхөн урьдчилсан цензур тавьж болохгүй гэсэн энгийн ойлгомжтой хориглосон заалт оруулах асуудлыг авч үзэх.
- Төрийн албан тушаалтан, байгууллага ил тод үйл ажиллагаа явуулах тухай 5.2 гэсэн заалтыг оруулснаар мэдээлэл авах эрхийг зохицуулсан тусгай хууль гаргах шаардлагагүй болно гэж ойлгож үл болно. Уг эрхийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх журмыг дэлгэрэнгүй зохицуулах хэрэгтэй.
- Хуулийн 7.4-ыг хасч, зар сурталчилгааны төлбөрийн асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон тэдгээрийн үйлчлүүлэгчийн мэдэлд үлдээх.
- Хэвлэл мэдээллийн ил тод байдлын талаарх заалтыг тодорхой хувь хэмжээ, жишээ нь 2 хувиас дээш хөрөнгө эзэмшиж байгаа бүх хувь нийлүүлэгчид хамааруулах.

3. Нууц эх сурвалж

Мэдээллийн эх сурвалжийг нууцлах тухай 6 дугаар зүйлд заасан байна. Хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд оролцогч аливаа этгээд мэдээллийг олж авахдаа эх сурвалжаа нууцлахаар тохирсон, мөн эх сурвалжаа ил болговол бусдын нэр төр, алдар хүнд, бизнесийн нэр хүндэд хор нөлөө учруулна гэж үзэж байвал

мэдээллийнхээ эх сурвалжийг хэлэхээс татгалзаж болно. Хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд оролцогчоос нийтлэгдсэн болон нийтлэгдээгүй мэдээллийг хаанаас, хэрхэн олж авсан талаар болон мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг тулган шаардах, мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, шийтгэхийг хориглоно.

Хэвлэл мэдээллийн ажилтан болон бусад этгээд мэдээллийн нууц эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрх нь үг хэлэх эрхийн нэг хэсэг юм. Тэгэхээр энэ эрхийг хамгаалах зохицуулалт оруулсан нь тун сайшаалтай хэрэг мөн. Гэхдээ холбогдох хэм хэмжээг ялимгүй сайжруулж, олон улсын стандартад илүү ойртуулж болохоор байна. Нэгд, хамгаалалтын хүрээ нь тодорхойгүй байна. Энд хэвлэн нийтлэх ажиллагаанд оролцогч гэж байгаа боловч хуульд зөвхөн нийтлэх гэдэг ойлголтыг тодорхойлсон байна.

Хуулийн хамгаалалтын хүрээг өргөжүүлж ердийн үед олон нийтэд мэдээлэл тарааж байгаа аливаа этгээд уг хамгаалалтыг эдэлнэ гэж заавал илүү байж болох юм. Европын зөвлөлийн Мэдээллийн эх сурвалжийг илчлэхгүй байх сэтгүүлчийн эрхийн тухай R(2000)7

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээлэл цуглуулан, тараах ажлыг байнга эсвэл мэргэжлийн түвшинд эрхэлдэг аливаа хувь хүн, хуулийн этгээд.³

дугаарын зөвлөмжид зааснаар хуулийн хамгаалалтыг эдэлнэ. Хоёрт, хамгаалалт үзүүлэх эсэх нь хэвлэл мэдээллийн ажилтан эх сурвалжаа илчлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төрд хортой гэж үзсэн эсэхээс хамаарахаар байна. Энэ нь зохимжгүй юм. Мэдээллийн нууц эх сурвалжууд өөрсдийгөө илчлэхгүй гэж үзсэн тохиолдолд сэтгүүлчдэд мэдээлэл өгдөг. Тэгэхээр сэтгүүлчид үүнийг өөрсдөө тааварлаж, хуульд заасан аль нэг ашиг сонирхол хохирохоор байвал мэдээллийн эх сурвалжаа хамгаалдаг байж таарахгүй.

Гуравт, хэвлэл мэдээллийн ажилтнаас илчлэхийг шаардаж болохгүй зүйлийн жагсаалт, тухайлбал, мэдээлэл хэрхэн олж авсан арга зам зэрэг нь нэг талаас хэт өргөн нөгөө талаас хэт явцуу байна. Хэвлэл мэдээллийн ажилтан эх сурвалжаа илчилж болохуйц мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй байх ёстой. Гэхдээ зөвхөн ийм мэдээллийн хувьд л түүний эрх хангагдана. Жишээ нь, мэдээллийг хэрхэн олж авсан тухай мэдээлэл нь эх сурвалжийг илчлэхгүй ч байх боломжтой.

ЗӨВЛӨМЖ:

- Эх сурвалжаа хамгаалах эрхийг мэдээллийг тогтмол эсвэл мэргэжлийн ажлын хүрээнд олон нийтэд түгээдэг аливаа этгээд эдэлнэ гэж өргөжүүлэх.
- Хэвлэл мэдээллийн ажилтан эх сурвалжаа илчлэх нь сөрөг үр дагавартай эсэх талаар юу гэж үзэж байгаагаас үл хамааран эх сурвалж өөрийгөө нууцлахыг хүссэн тохиолдолд дээрх эрх хэрэгждэг байх.
- Дээрх эрх нь эх сурвалжийг илчлэхэд хүргэж болох аливаа мэдээлэлд хамаарах боловч түүнээс халихгүй байх.

4. Өөрийн зохицуулалт

Хуулийн 9-р зүйлд өөрийн зохицуулалтын тогтолцоо маягийн зүйл бий болгох тухай заажээ. “Хэвлэл мэдээлэл нь өөрийгөө удирдах, хянах, ёс зүйн зохицуулалт хийх үүрэг бүхий хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын тогтолцоотой байна. Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын тогтолцооны бүх мэдээлэл олон нийтэд нээлттэй байна. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, хэвлэлийн мэдээллийн агуулгатай холбогдсон асуудлаар хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын тогтолцооны аль ч байгууллагад иргэн, байгууллага гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, хэвлэлийн мэдээллийн агуулгатай холбогдуулан иргэн, байгууллагаас шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад гомдол гаргасан бол уг гомдлыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын тогтолцоон дахь гомдол гаргагчийн зөвшөөрсөн аль нэг байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.”

Өөрийн зохицуулалт гэдэг бол олон нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх хоёр зорилгыг зэрэг хангах шилдэг арга юм. Тиймээс ийм тогтолцоог дэмжих нь зүйтэй. Ардчилсан олон улс оронд хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл бүрэн хэмжээгээр өөрийн зохицуулалтад орсон байдаг бол радио, телевиз нь хуулиар тогтоосон ёс зүйн дүрэмтэй байдаг. Энэ нь радио, телевиз чанарын хувьд огт өөр гэдгийг харуулахын зэрэгцээ эдгээр нь нийтийн шинж чанартай хомс нөөц болох агаарын долгионыг ашиглаж байгаагийн хувьд илүү хатуу зохицуулалт шаарддаг байна. Хэдийгээр хуулийн төсөлд өөрийн зохицуулалтыг авч үзсэн нь сайшаалтай боловч санал болгосон тогтолцоо нь хэд хэдэн дутагдалтай байна.

Хамгийн гол дутагдал нь хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өөрийн тогтолцоог бүрдүүлэх эрхийг олгоогүй атлаа хууль өөрөө шууд уг тогтолцоог бүрдүүлэх ямар нэг механизм бүрдүүлээгүй байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ийм тогтолцоотой байна гэдгийг л дурдах төдийгөөр хязгаарлажээ. Ийм тогтолцоо хэрэгжих наад захын хоёр нөхцөл

³ 2000 оны 3 дугаар сарын 8-нд Сайд нарын зөвлөлөөс баталсан.

шаардагдана. Нэгд, уг тогтолцоо нь хэвлэл мэдээллийн бүх байгууллагын оролцоог хангасан байх ёстой. Хоёрт, уг тогтолцоо нь гомдол хүсэлтийг шаардлага хангахуйц хэмжээнд барагдуулдаг байх ёстой.

Одоо болтол Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл янз бүрийн шалтгаанаар өөрийн зохицуулалтын тогтолцоо бүрдүүлж чадаагүй байхад хуулийн төсөлд байгаа ганцхан заалт яаж энэ асуудлыг шийдэх юм бол гэсэн эргэлзээ төрж байгаа юм. Янз бүрийн иргэний нийгмийн байгууллага өөрийн зохицуулалтын тогтолцоонууд байгуулах оролдлого хийсэн боловч эдгээр нь хэвлэл мэдээллийн итгэлийг хүлээх чадваргүй эсвэл хоорондоо өрсөлдөх байдалтай болж ирсэн. Мөн ийм тогтолцоо иргэдийн гомдол хүсэлтийг барагдуулж, хохирлыг нь арилгах чадвартай байх эсэх нь тодорхойгүй байна.

Монголын урьд өмнөх туршлагаас харахад хуулийн төсөлд орсон маш ерөнхий заалт хэрхэн өөрийн зохицуулалтын нэгдсэн, үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлэх бол гэдгийг төсөөлөхөд үнэхээр хүндрэлтэй байна. Монголын шийдвэр гаргах түвшинд авч үзэж болох бодитой хэрэгжих боломжтой хоёр хувилбар байна. Эхнийх нь хуульд заахгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрөө өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болгох нэмэлт хугацаа өгч хүлээх. Ингэхдээ хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрсдөө өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болгохгүй бол төрөөс хууль гаргаж ийм тогтолцоо байгуулах тухай мэдэгдэл хийсэн ч болно.

Хоёрт, хэвлэлийн зөвлөлийг хуулиар байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтлах дүрмийг боловсруулах бүрэн эрх олгож болно. Хэрэв ингэнэ гэвэл зөвлөлийн хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж өгөх шаардлагатай. Жишээ нь, зөвлөлийн удирдах байгууллагын бүрэлдэхүүнд төрийн албан тушаалтан оруулахгүй зөвхөн хэвлэл мэдээллийн ажилтан, олон нийтийн төлөөлөл байна гэж хуульчилж болно. Цаашилбал, уг байгууллагын санц хэрэглэх эрх хэмжээг хязгаартай байлгаж, хэвлэл мэдээллийг хяналтдаа оруулах боломжийг багасгах нь зүйтэй. Жишээ нь, тухайн хэвлэл мэдээллийн байгууллага дүрэм зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол үүнийгээ хүлээн зөвшөөрч мэдэгдэл хийхийг даалгадаг санц байж болно.

Дээрхээс гадна 9-р зүйлийн 3 мөн л учир дутагдалтай болжээ. Иргэн өөрийн зохицуулалтын тогтолцооны дагуу гомдол гаргаж тийш нь эхлээд хандаагүй байсан ч түүний шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хаах нь хууль бус зохицуулалт юм. Харин өөрийн зохицуулалтын тогтолцоог ашиглаагүй тохиолдолд шүүх хохирлын хэмжээг тогтоохдоо харгалзан үздэг байж болно. Тухайлбал, энэ тохиолдолд хохирлын хэмжээг бууруулж тогтоодог байж болно. Түүнчлэн дээрх хэм хэмжээ тухайн гомдол гаргагч асуудлаа өөрийн зохицуулалтын тогтолцоонд хандаж шийдвэрлүүлэх сонирхолгүй байх тохиолдлыг харгалзаж үзээгүй байх бөгөөд тэр тохиолдолд асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх нь ойлгомжгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хуулийн төсөлд тусгасан өөрийн зохицуулалтын тогтолцооны үзэл баримтлалыг бүхэлд нь дахин боловсруулах шаардлагатай. Нэг бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болгохыг хүлээх эсвэл гомдол шийдвэрлэх тогтолцоог хуулиар шууд бий болгох нь зүйтэй.
- Ямар ч тохиолдолд, гомдол гаргагч өөрийн зохицуулалтын тогтолцоог алгасан шууд шүүхэд хандаж хамгаалуулах эрхтэй байх ёстой ба үүнийг хохирлын хэмжээг тогтоохдоо харгалзаж болно.

5. Гүтгэн доромжлох

Хуулийн төслийн 10-р зүйлд гүтгэн доромжлох үйлдэлд холбогдох хэд хэдэн заалт оржээ. Уг зүйлд зааснаар нэр төр, ажил хэргийн нэр хүнд, алдар хүнд гутаагдсан, хэвлэлээр гүтгэсэн асуудлаар нэхэмжлэл, гомдол гаргасан этгээд нь хэвлэлээр нийтлэгдсэн мэдээлэл үндэслэлгүйг болон өөрийн хохирсоныг нотлох үүрэгтэй.

Цаашилбал, төрийн албан хаагч, улс төрийн намын удирдлага нь нэр төр, ажил хэргийн нэр хүнд, алдар хүнд гутаагдсан тухай нэхэмжлэлийг зөвхөн хувь хүний нэрийн өмнөөс гаргана гэж заажээ.

Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлүүдэд хүний нэр

төрийг хамгаалах асуудлыг зохицуулсан байна. Уг хуулийн 110-р зүйлд хүний нэр төр, алдар хүндийг олон нийтийн хэвлэлээр санаатайгаар доромжлон гутаах гэмт хэргийг заажээ. Энэ гэмт хэрэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Мөн хуулийн 111-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол өмнөхтэй адилхан ял шийтгэнэ. Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд нь ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. Эцэст нь хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

Хуулийн төслийн 10-р зүйлийн гол дутагдал нь уг зүйл Эрүүгийн хуулийн бусдыг доромжлох, гүтгэх гэмт хэрэгтэй хэрхэн холбогдож байгаа нь ойлгомжгүй байгаа явдал юм. Ялангуяа 10-р зүйлээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн зорилго байна уу гэдэг нь тодорхойгүй байна. Хэрэв 10-р зүйл Эрүүгийн хуулийг өөрчлөх зорилгоор хийгдээгүй бол уг заалт чухам ямар зорилготой, ач холбогдолтой вэ гэдгийг ойлгоход бэрх байна.

Хэрэв 10-р зүйл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа бол энэ зорилгодоо нийцүүлэн сайн боловсруулаагүй байна. Тухайлбал, 10-р зүйл нь гүтгэн доромжлох гэдэг нь зөвхөн үнэн эсвэл худал баримтад тулгуурлан хүнийг буруутгах тохиолдлууд байна гэж тооцож байна. Гэвч Эрүүгийн хуулийн 110-р зүйлд баримтад тулгуурлахгүйгээр хүнийг буруутгах тохиолдол байж болохыг заажээ. Үүнээс бүр чухал асуудал бол 10-р зүйлээр гүтгэн доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх, түүнийг иргэний эрх зүйн асуудал болгон өөрчлөх зэргээр олон улсын эрх зүйн шаардлагад нийцүүлэх гэсэн зорилго байхгүй байна.

Ядаж олон улсын эрх зүйд маш ноцтой гэж тооцогдож байгаа гүтгэн доромжлох гэмт хэрэгт хорих ял оноодог асуудлыг халах тухай ч санаа илэрхийлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Энэ хуулийн агуулгыг тодорхой болгож, 10-р зүйлээр Эрүүгийн хуулийн гүтгэн доромжлох гэмт хэргийг халах зорилгоор өөрчлөн томъёолох.
- 10-р зүйлд зөвхөн бодит үнэнийг гуйвуулсан тохиолдолд хариуцлагад татагдана гэж ойлгогдохоор болгож өргөжүүлэх. Гүтгэн доромжлох үйлдлийг иргэний зөрчил гэж үзэх, бүр ядлаа гэхэд энэ гэмт хэргийн төлөө хорих ял оноодог явдлыг болиулах зорилготой болгох.

Нээлттэй Нийгэм Форум

Нээлттэй Нийгэм Форум нь 2004 оны зургадугаар сард Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /Соросын сан/-г өөрчлөн байгуулсны үндсэн дээр бий болсон Монголын төрийн бус байгууллага юм. Нээлттэй Нийгэм Форумын үндсэн зорилго нь чанартай мэдээлэл, судалгаа, олон талт хэлэлцүүлэгт тулгуурлан төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад иргэдийн идэвхитэй оролцоог дэмжихэд оршино.

ННФ иргэний нийгмийн бусад байгууллагатай нягт түншлэн ажиллахын сацуу парламент, засгийн газартай өргөн хүрээнд хамтран ажилладаг. Мөн улс оронд өрнөж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцын талаар донор болон олон улсын байгууллагуудтай байнга зөвлөлддөг болно.

ННФ-ын Хэвлэл Мэдээллийн Хөтөлбөр

ННФ-ын Хэвлэл мэдээллийн хөтөлбөрийн гол зорилго нь Монгол Улсын тогтвортой ардчиллын төлөөх арга хэрэгслэл болох хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах явдал юм.

Энэ хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих зорилгоор сэтгүүлчдийн эрх чөлөөнд халдаж буй зөрчлийн мониторинг хийх, Олон Нийтийн Радио, Телевиз нь иргэдийн эрх ашиг, сонирхолд нийцсэн нийтлэл нэвтрүүлэг хийж буй эсэх талаар мониторинг хийх үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн эрх зүй, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтын механизмын асуудалд түлхүү анхаарч байна. Мөн сэтгүүлчдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, ялангуяа эдийн засаг, хөгжлийн холбогдолтой мэдээлэл түгээхэд сэтгүүлчдийн үүрэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ННФ нь Лондон дахь Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран Глоб Интернэшнл, Хэвлэлийн Хүрээлэн зэрэг байгууллагыг дэмжиж ажилладаг.